



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны 10 сарын ᠐᠔ өдөр

Дугаар 129

Цагаантолгой

Газар эзэмшүүлэх дуудлага  
худалдаа явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12-р сарын 20-ны өдрийн 25 тоот тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03-р сарын 14-ны өдрийн 40 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сант сумын Ивэн 1-р баг, Хушаат 2-р багийн нутаг дэвсгэрт дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр тусгагдсан 7 нэгж талбар бүхий 15.57 га газрыг эзэмшүүлэх дуудлага худалдааг явуулсугай.
2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны тов, тухайн нэгж талбарын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, хугацаа, дэнчингийн хэмжээг нэгж талбар тус бүрээр энэхүү захирамжийн хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг товдлогдсон хугацаанд журмын дагуу зохион байгуулахыг сумын Газрын даамал (Ц.Батсайхан)-д даалгасугай.

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Ч. Доржсайхан  
Хянасан: Ч. Агшисүрэн  
Хувь: 2  
Огноо: 2020 12 04

Сант сумын Засаг даргын .....-оны /0...-р сарын .....-ны өдрийн 129 ..... тоот захирамжийн хавсралт

№	Нэгж талбарын Дугаар	Цахим дуудлага худалдаагаар эзэмшүүлэх нэгж талбар						Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны анхны үнэ / төг/	Эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа /жил/	Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны дэнчингийн хэмжээ / төг/
		Сум	Байршил	м2	Га	Зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах өдөр			
1	2680659		Хушаат 2-р баг Цагаантолгой	491	0.04	Зоорь	2022.11.07	392800	15	39280
2	2695131		Ивэн 1-р баг Дэлгүүрийн ард	108	0.01	2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	2022.11.07	86400	15	8640
3	2695132	Сант	Ивэн 1-р баг Дэлгүүрийн ард	51	0.005	2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	2022.11.07	40800	15	4080
4	2695133		Хушаат 2-р баг Наймт	110682	11.06	4104: Мод үржүүлгийн газар	2022.11.07	1946560	15	194656
5	2471351		Хушаат 2-р баг Хөндлөн рашаан	13093	1.3	2503: Аялал жуулчлалын бааз	2022.11.07	10474400	15	1047440
6	2472930		Хушаат 2-р баг Мянгадарь	11535	1.15	2503: Аялал жуулчлалын бааз	2022.11.07	9228000	15	922800

7	2491271	Хушаат 2-р баг Орхон, Ивэн голын уулзвар	20130	2	4104:Мод үржүүлгийн газар	2022.11.07	352000	15	35200
		<b>Нийт</b>	<b>156090</b>	<b>15.57</b>			<b>22520960</b>		<b>2252096</b>